

Угаагч шлюзнууд




Зориулалт:

Үнэт металлуудын шороон ордод олборлолт явуулахад хэрэглэнэ. Гүн дүүргэлтийн шлюз (ШГМ) гүехэн дүүргэлтийн шлюзыг (ШММ) ашигт малтмал болон эрдэс чулуулгийн нягтрал нэлээд ялгаатай байгаа үед хүдэр болон шороон малтмалыг усан орчинд баяжуулахад хэрэглэнэ.

Дүрслэл:

Шлюз гэдэг нь ёроолдоо алтны ширхэгүүдийг барих резинэн хивсэнцэр байрлуулсан хайрцаг юм. Хивсэнцэр дээр усны урсгалын зүгт тодорхой хэмд налсан налуу хавтанцаруудаас бүрдэх металл трафарет байрлана. Эдгээр трафаретыг металл хавчааруудаар хивсэнцэрт бэхлэнэ. Шлюз дээд талдаа хайрс хэлбэртэйгээр дээр дээр нь зөрүүлж тогтоосон металл хаалтуудаар хаагдах ба гадны хүн шлюзад орохоос сэргийлэнх үүднээс хаалт цоожтой.



Гүйцэтгэлийн хувилбарууд:

- Шлюзыг гүн болон гүехэн дүүргэлтийнх, шулуун болон булангийнх, өргөссөн болон нарийссан зэрэг хэлбэрээр үйлдвэрлэдэг.
- Шлюз нэг тасалгаа, хоёр тасалгаа, гурван тасалгаа болон дөрвөн тасалгаатай байдаг.
- Шлюзны өргөн нь төхөөрөмжийн гүйцэтгэлээс хамаарна, өргөн нь 0,4 м-с 1,0 м хүртэл байна.
- Шлюзны уртыг захиалагчийн хүслээр гүйцэтгэнэ.

Захиалагчийн хүсэлтээр шлюзыг чарга дээр тодорхой өнцөгөөр хөдөлгөөнгүй хүрээнд суурилуулж болно. Мөн түүнчлэн шлюзыг хоёр гадаргууд тохируулагддаг налуугаар хийж болно.